



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/494

Арвайхээр

Тендер хүчингүй болгож, шууд  
гэрээ байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 83 дугаар дүгнэлтийн дагуу Боловсрол, соёлын байгууллагуудын барилгын их засварын ажлын 1 дүгээр багц Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажлыг хүчингүй болгосугай.

2. Боловсрол, соёлын байгууллагуудын барилгын их засварын ажлын 1 дүгээр багц Бүрд сумын Ерөнхий боловсролын сургуулийн их засварын ажилд шууд гэрээ байгуулсугай.

3. Дээрх хүчингүй болсон багцад шууд гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-т даалгасугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101087